



МОНГОЛЫН ЗАГАСЧЛАЛЫН СПОРТЫН ХОЛБОО МОНГОЛЫН ФЛАЙ ФИШИНГИЙН БАГ

2024 МАСТЕРУУДЫН БА ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ФЛАЙ ФИШИНГИЙН ТЭМЦЭЭНҮҮД

АЛБАН УРИЛГА

Загасчлалын спортын ахмад тамирчдыг МЗСХ 2024 Мастеруудын (ахмадын) ба эмэгтэйчүүдийн флай фишингийн тэмцээнүүдэд урьж байна.

Зохион байгуулагч: Монголын флай фишингийн баг

Зорилго: Флайн загасчлалын спорт, зүй зохистой загасчлалыг сурталчлах, флайн ахмад болон эмэгтэй загасчдыг дэмжих, цаашлаад Мастеруудын ба эмэгтэйчүүдийн ДАШТ-д оролцох эхлэлийг тавих.

Болох газар: Төв аймгийн Мөнгөнморьт сум, Хэрлэн гол

Болох хугацаа: 2024 оны 8-р сарын 30-31.

Дүрэм, журам: МЗСХ-ны Флай фишингийн тэмцээний дүрмээр. Энэ тэмцээнд мөрдөх дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг хавсаргав.

Оролцогчид: Мастеруудын тэмцээнд 1974 он ба түүнээс өмнө төрсөн хүмүүс оролцоно. Эмэгтэйчүүдийн тэмцээнд 2008 он ба түүнээс өмнө төрсөн эмэгтэйчүүд оролцоно. Оролцогчид бүртгүүлэхдээ иргэний үнэмлэх эсвэл түүнтэй дүйцэх бичиг баримтаа үзүүлнэ.

Оролцох эрхийн төлбөр: 100'000 төгрөг. Энэхүү төлбөрийг Голомт банкны 4605105031 тоот дансанд (эзэмшигч: Б.Амгаланбаатар, гүйлгээний утга: Овог нэр, харилцах утасны дугаар) шилжүүлнэ.

Бүртгэл: 2024 оны 8-р сарын 27-ны өдрийг дуустал бүртгэнэ.

Шүүгчид: МЗСХ-ны шүүгчид

Шагнал: Тэмцээнийг хувийн үзүүлэлтээр дүгнэж эхний 3 байр эзэлсэн тамирчдыг шагнана.

Холбоо барих: Б.Амгаланбаатар (гар утас 99019666, FB Амаанаа Вуамбасурен).



МОНГОЛЫН ЗАГАСЧЛАЛЫН СПОРТЫН ХОЛБОО МОНГОЛЫН ФЛАЙ ФИШИНГИЙН БАГ

2024 МАСТЕРУУДЫН БА ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ФЛАЙ ФИШИНГИЙН ТЭМЦЭЭНҮҮДИЙН ДҮРМИЙН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

1. Тэмцээнд оролцогчид унаа, байр, хоолоо өөрсдөө хариуцна.
2. Тэмцээнд оролцогчид нэг хэсэгт 3 үеийн турш өрсөлдөнө.
3. Оролцогч бүрийн ард нэг хянагч байрлаж флай фишингийн тэмцээний дүрмийн хэрэгжилт, загасчлах явцыг хянах ба оролцогчийн барьсан загасыг хэмжиж тэмдэглэнэ.
4. Нэг үе нь 3 цаг үргэлжлэх ба эхний 1 цаг 30 минутын дараа секторын шүүгчийн дохиогоор оролцогчид загасчлалаа зогсоож загасчлах хэсгээ (beat) солилцоно. Ингэхдээ 1-р хэсгийн оролцогч 2-р хэсгийн оролцогчтой, 15-р хэсгийн оролцогч 16-р хэсгийн оролцогчтой гэх мэт харилцан гэх солилцоно. Загасчлах хэсгээ солилцоход 15 минут зарцуулах ба секторын шүүгчийн дохиогоор загасчлалаа үргэлжүүлнэ. Нийт 3 цагийн туршид барьсан загаснуудын уртаар байр эзлүүлнэ.
5. Тэмцээнд зэвэг, хадран, тул, улаан живэрт, Амарын сугас загасыг тооцох ба зөвшөөрөгдөх доод хэмжээ нь 20 см байна. Жич, 20 см хүрээгүй загасыг тооцохгүй, 21 см хүрээгүй загасыг 20 см-ээр тооцно.
6. Тэмцээний секторуудын шугамыг татсаны дараа сектор дотор бэлтгэл хийх, загасчлахыг хатуу хориглоно. Хэрэв тухайн зөрчлийг гаргавал тэмцээнээс хасна (улаан карт).
7. Тэмцээний үеэр хянагчид, дасгалжуулагчид эргээс 10 метр, үзэгчид 20 метрээс багагүй зайд байрлана. Ханагч нь зөвхөн загасчилж буй тамирчны зөвшөөрлөөр эрэг рүү ойртоно.
8. Хэвлэл мэдээллийнхэн, зураглаачид зохион байгуулагчдын мандатаар нэвтрэх ба зөвхөн загасчилж буй тамирчны зөвшөөрлөөр эрэг рүү ойртоно.
9. Оролцогчид өөрсдийн аюулгүй ажиллагааг сайтар хангаж оролцоно.
10. Тэмцээний аливаа үеийн туршид согтууруулах ундаа хэрэглэх, хэрүүл маргаан гаргахыг хатуу хориглоно! Энэ зөрчлийг гаргасан тамирчин, дасгалжуулагчдыг Ерөнхий шүүгч тэмцээнээс хасах (улаан карт) эрхтэй.
11. Голын эрэг, ус руу хог, тамхины иш хаяхыг хориглоно.

Монголын загасчлалын спортын холбооны флай фишингийн хэлтэс
Монголын флай фишингийн баг



МОНГОЛЫН ЗАГАСЧЛАЛЫН СПОРТЫН ХОЛБОО МОНГОЛЫН ФЛАЙ ФИШИНГИЙН БАГ

2024 МАСТЕРУУДЫН БА ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ФЛАЙ ФИШИНГИЙН ТЭМЦЭЭНҮҮДИЙН ХӨТӨЛБӨР

2024 оны 8-р сарын 29

19:00 Хэрлэн голын эрэгт байрлах явуулын штаб техникийн зөвөлгөөн, хуралтай. Хурал дээр тэмцээний дүрмийг дахин танилцуулж, аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч гарын үсэг зуруулан, тамирчдын загасчлах хэсгийн сугалааг явуулна.

2024 оны 8-р сарын 30

09:00-12:30 Тэмцээний 1-р үе.
13:00-14:30 Чөлөөт цаг.
15:00-18:30 Тэмцээний 2-р үе.
20:00-20:30 Тэмцээний нээлтийн ёслол.
22:30 Амралт.

2024 оны 8-р сарын 31

08:30-12:00 Тэмцээний 3-р үе.
14:00-14:30 Шагнал гардуулах ёслол.

ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС